

## БОРЖИГИН ОВОГТ БАЯГУД ЯСТ ХАНДЫН НЯМБУУ<sup>1</sup>

(1942-1998)

*С.Бямбадорж*

*МУИС, Антропологи, Археологийн тэнхим, ахлах багш,*

*А.Жамбал*

*Философийн хүрээлэн, ахмад ажилтан*

*Ц.Пүрэв*

*Философийн хүрээлэнгийн “Социологийн сектор”, доктор, профессор*

*Ч.Тамир*

*МУИС-ийн ШУС-ийн дэд захирал, дэд профессор*

*Ц.Болд*

*МУИС, Социологи, Нийгмийн ажлын тэнхим, ахлах багш*

*Б.Цэцэнцолмон*

*МУИС, Антропологи, Археологийн тэнхим, ахлах багш, доктор (Ph.D)*

### 1. Х.Нямбуугийн гарал үүсэл, бага нас

Х.Нямбуу 1942 оны усан морь жилийн 8 дугаар сарын 5-нд тэр үеийн Төв аймгийн Баян-Өнжүүл сум, одоогийн Дундговь аймгийн Адаацаг сумын нутаг «Хаяа хонд» гэдэг газар боржигин халх, малчин Хандын найм дахь хүүхэд болж төржээ. Эх Ханд нь 1907 онд төрсөн, хувийн мал ахуйгаа эрхлэн аж төрж байгаад 1950-аад оны сүүлчээр «Амьдралын туг» нэгдэлд малаа нийгэмчлүүлэн гишүүн болжээ. Хандын эх буюу Нямбуугийн эмэг эх Сосор (1875-1951) мөн насаараа малчин байсан, хожим Х.Нямбуугийн бичсэнчлэн «Өсөхөөс үс цайтал мал дагаж явсан хүн» ажээ. Х.Нямбуу Дашзэвэг (МУИС-ийн сэтгүүлчийн анги төгссөн), Даваа, Шагдар (малын бага эмч), Жигмид (малчин) гэсэн дөрвөн ахтай, Батсүрэн гэдэг дүүтэй байжээ.

Х.Нямбуу багадаа хөдөөгийн бусад хүүхдийн нэгэн адил хонь мал хариулж эх, эмээдээ тус дэм болж өсөхийн хамт ой ухаан нь сониуч сэргэлэн, номын дуу сонсож, эрдэм номонд дуртай болж хүмүүжих хувь заяатай нэгэн байжээ. Учир нь түүний эмэг эх Сосор, эх Ханд, нагац ах Лувсанчой, нагац эгч Ичинхорол нар нь эрт урдын түүх шастир, ном судар мэддэг, цээжээр хэлдэг, монгол, төвд бичигтэй хүмүүс байсан нь Нямбуу хүүг ном эрдэмд дурлаж тэмүүлж өсөх, хожим нь нийгэм, хүмүүнлэгийн ухааны нэрт эрдэмтэн болоход нөлөөлжээ. Х.Нямбуу гэрийнхнийхээ тухай “Манайх бурхан их тахидаг, нэгдэлд ортлоо бурхнаа нууцлан тахиж, жасаагаа уншуулж даллага авдаг байв. Малын сэтэр, домын санг ээж минь өөрөө тавина. Энэ бүх ёслол үйлдлийг балчраасаа сонирхдог байсан нь угсаатны зүйг судлахад нөлөөлсөн байх” гэжээ (Х.Нямбуу, 1993).

Х.Нямбуу 1950-1957 онд Төв аймгийн төвийн 10 жилийн дунд сургуульд суралцаж 7 дугаар анги төгсөөд Улаанбаатар хотод ирж 1957-1960 онд нийслэлийн 10 жилийн 2 дугаар дунд сургуулийг дүүргэжээ.

### 2. Оюутан Х.Нямбуу

Х.Нямбуу 1960-1965 онд МУИС-ийн монгол хэл, уран зохиолын ангид суралцаж амжилттай төгсчээ. Тэр бээр шинэхэн оюутан нэгдүгээр курст байх үеэсээ эхлэн Х.Пэрлээ,

<sup>1</sup> Тайлбар: “Философи эрхийн судлал” цувралын 2012 оны ХХҮИ ботид Ц.Пүрэв, А.Жамбал нарын бичсэн “Монголын анхны социологичдын нэг, угсаатан, ёс заншил судлалын нэрт эрдэмтэн Хандын Нямбуу” хэмээх өгүүлэл хэвлэгдсэн. Зохиогчдын зөвшөөрөлтэйгөөр уг өгүүлэлээс хэсэгчлэн авч энэхүү өгүүллийг бүтээв.

Б.Ринчен багш нараа дагалдан хөдөө судалгаанд явж, өөрийнх нь хэлснээр угсаатны зүйн талаар “удирдан зааж чиг замыг нь гаргаж өгсөн” хэмээн дээрх багш нараа нэрлэжээ (Х.Нямбуу, 1993).

1961 оноос эхлэн “Сурган хүмүүжүүлэгч” сэтгүүл “Эцэг эх, сурган хүмүүжүүлэгч нарт зөвлөгөө” гэсэн булан нээж, хүүхдийн хүмүүжлийн сэдвээр олон тооны өгүүлэл, зөвлөгөө нийтэлж эхэлжээ (Ц.Өлзийхутаг, Н.Цэдэвсүрэн, 1974). Х.Нямбууг багш нар нь холбож өгсөн болов уу, Х.Нямбуу хоёрдугаар курс төгсөхдөө тус сэтгүүлд 1962 оны №3 дугаарт “Монголчуудын мэндлэх ёсноос” хэмээх хоёр хуудас нийтлэлийг анх удаа гарган урамшиж улмаар тэр ондоо тус сэтгүүлийн №5 дугаарт, “Монголчуудын зочлох ёсноос”, №6 дугаарт “Зочин хүний гүйцэтгэх үүрэг” хэмээх гурван хуудас зөвлөгөө гаргаснаар эрдмийн ажлын сайхныг мэдэрсэн буй за.

Монгол угсаатны зүйг шимтэн сонирхож, 3 дугаар курсийн оюутан байхдаа оюутны эрдэм шинжилгээний хурлуудад амжилттай оролцож МУИС-ийн хэмжээнд шалгаран, “Монгол гэрийн үүсэл хөгжлөөс товчхон”, “Дархад эмээлийн зүйлээс товчхон” (Х.Нямбуу, 1963) гэсэн хоёр өгүүллийг 1963 оны III дугаарт цугт нь хэвлүүлж уншигчдад танил болжээ.

Түүний “Дархад эмээлийн зүйлээс товчхон” өгүүлэлд “1962 онд Дархад нутагт очиж тэдний эмээлийг бага зэрэг ажигласан зүйлдээ дулдуйдан” гэсэн талбарт очиж судалгаа хийж байсныг илтгэх өгүүлбэр бий. Үү курсийн оюутан байхдаа монголын анхны угсаатны зүйч эрдэмтдийн нэг, өөрийнх нь багш С.Бадамхатантай хамтран “Дархад ардын дээл” (С.Бадамхатан, Х.Нямбуу, 1964) хэмээх өгүүллийг ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн “Халх Дархадын этнографийн бүтээл” -д хэвлүүлэв.

Үүний зэрэгцээ тэрээр оюутан байхдаа «Уран үснийхний гэр бүлийн намтар» (Бийрийн тухай өгүүлүүд. Уб., 1963), «Хар чулууныхны гэр бүлийн намтар» (Харандааны тухай өгүүлүүд. Уб., 1964), «Овоохой овогт гэрийн намтар» (Уб., 1965) гэсэн танин мэдэхүйн агуулгатай, хүүхдэд зориулсан товхимол нийтлүүлжээ. Дээрх бүтээлүүдээс харахад тэрээр оюутан байх цагаасаа эхлээд угсаатны зүйн чиглэлээр ажиллах өөрийн сонирхлоо олж, багш нарынхаа зөвлөгөө, заавраар ажиллаж эхэлсэн байна.

### **3. Улсын музей**

Х.Нямбуу нь МУИС-аа төгсөөд Улсын төв музейд угсаатны зүйч, музейн тайлбарлагчаар ажиллаж ажил амьдрал, эрдмийн гараагаа эхэлсэн байна. Энд ажиллаж байхдаа бие даасан анхны судалгаа болох “Халхын зарим нутгийн хээ угалзны зүйлээс” (XIX-XX зууны эхэн) (УБ.,ШУАХ,1967) хэмээх бүтээлээ бичин Түүхийн хүрээлэнгийн “Этнографийн цуврал”-аар хэвлүүлжээ. Тэрээр музейд ажиллаж байсан үеэ “Бүх аймгийн орон нутгийг судлах музей байгуулахад оролцсон. Хотын бүх том музейн тооллогод оролцсон. Энэ бүхэн нь олон үеийн элдэв эдлэл хогшлыг танин мэдэх том сургууль болсон юм (Х.Нямбуу, 1993) гэж дурссан. Чухам энэ үед Х.Нямбуу монголд гарсан музей судлалын анхны сэтгүүлд “Монгол дархын үйлээс”, Ж.Цэвэгсүрэнгийн хамт “Нэгэн монгол тулганы бүтэц, хөгжлийн онцлогоос” хэмээх сонирхолтой өгүүлүүдийг тэрлэсэн. Ингэж түүний өөрийнх нь хэлснээр угсаатны зүйгээрээ “ид сайхан зүгшрэх төлөвтэй болж байтал 1969 онд музей маань Соёлын яаманд шилжлээ. Тэгтэл Б.Ширэндэв гуай намайг социологид сур! гэж албадан томилчихдог юм байна” (Х.Нямбуу, 1993) гэж дурсан бичжээ. Х.Нямбуугийн социологич болсон түүх нь ийм учиртай юм. Ингээд тэрээр 1969-1972 онд Монголын Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэнгийн дэргэд байгуулагдсан “Түн ухаан, хууль цаазын тасаг”-г эрдэм шинжилгээний ажилтнаар шилжин ажиллаж, социологич мэргэжлээр шамдан суралцаж эхлэв.

#### 4. ФСЭХ-ийн социологич Х.Нямбуу

Түүхийн хүрээлэнд «Гүн ухаан, хууль цаазын тасаг» байгуулагдаад гурав дахь жил болж байхад Ч.Жүгдэр, Б.Самбуу нарын дараа 1969 оны 9 дүгээр сард тус тасгийн гурав дахь ажилтнаар ирсэн ба түүний амьдрал, эрдэм судлал, бүтээл туурвил нь ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн, ялангуяа түүний Социологийн хэлтэстэй салшгүй холбогдож, эрдэм судлалын энэхүү гал голомтын тулгын гурван чулууны нэг болсон юм. Тиймээс хүрээлэнгийн үүх түүх, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа, түүний ололт амжилтын талаар дурдахад Х.Нямбуугийн эрдмийн бүтээл туурвил, үүрэг оролцоо зайлшгүй хамт яригддаг.

1972 онд ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн «Гүн ухаан, хууль цаазын тасаг»-ийг өргөтгөн Философи, социологи эрхийн хүрээлэн байгуулагдаж Социологийн секторын эрхлэгчээр Х.Нямбуу ажиллаж эхэлсэн бөгөөд улмаар 1983 оныг хүртэл ажиллаж монголд социологийн шинжлэх ухааныг үндэслүүлэн хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулсан юм.

Х.Нямбууг Төв музейд ажиллаж байхад нь ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Ширэндэв гуайн саначлагаар 1969 оны 5-р сард Ж.Ламжав, Б.Самбуу нарын хамт ЗХУ-д социологийн ухаанаар мэргэжил дээшлүүлэхээр томилон явуулах шийдвэрийг ШУА-ийн тэргүүлэгчдийн газар гаргаж, тэрчлэн явуулан сургажээ (БНМАУ-ын ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын тогтоол. 1969.05.27, 2012). Ц.Пүрэв, А.Жамбал нар Х.Нямбуу багшийн талаар бичсэн намтартаа, «Ширэндэв гуай Х.Нямбууг Гүн ухаан, хууль цаазын тасагт 1969 оны 9 сарын 25-нд шилжүүлэн авч ажиллуулсан, гэхдээ түүнийг ШУА-д шилжүүлэн авах асуудал нэлээд түрүүнд шийдэгдсэн байжээ» (Ц.Пүрэв, А.Жамбал, 2012) хэмээн дүгнэсэн байдаг. Х.Нямбууг ШУА-д шилжүүлэх асуудал эртнээс шийдэгдсэнээр барахгүй, түүнийг “Социологич” болгон мэргэшүүлэх шийдэл ч алсаас боловсрогдож углуургатай бэлдэж байжээ хэмээн тодруулан дүгнэж болох юм.

Х.Нямбуу нь 1969 оны 9-р сард монголоос анх удаа ЗХУ-ын ШУА-ийн “Нийгмийн тодорхой судалгааны хүрээлэн” болон Москвагийн их сургуульд социологийн ухаанаар мэргэжил дээшлүүлсэн. Дараа нь Б.Ширэндэв гуай Х.Нямбууг дагуулан Лениний мэндэлсний 100 жилийн ойд зориулсан ЗХУ-ын ШУА-ийн хүндэтгэлийн чуулганд оролцсоны (Үндэсний Төв Архив. Ф-23, Д-2, ХН-633, 52 дахь хуудас.) зэрэгцээ, 1970 оны 9 дүгээр сард БНБАУ-ын Варна хотноо болсон Дэлхийн социологичдын VII их хуралд С.Норовсамбуу, Ч.Жүгдэр, Х.Нямбуу, Ж.Роозон нарыг оролцуулжээ (Ц.Пүрэв, А.Жамбал, 2012). Энэ тухайгаа Х.Нямбуу шинээр социологич болохын тулд “Юун түрүүнд жаал ном уншлаа. Варнад болсон социологичдын хурлын илтгэлүүдтэй танилцлаа” (Х.Нямбуу, 1993) гэжээ.

Улмаар 1972 оны 7 дугаар сарын 15-нд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 193 дугаар тогтоолоор ФСЭХ байгуулагдсаны (Г. Чулуунбаатар, 2012) дараахан Польш руу томилон явуулж, социологийн ухаанд суралцуулж, мэргэжил дээшлүүлсэн байна. Энэ талаар, тухайн үед Польшид социологич мэргэжлээр суралцаж байсан Я.Мөнхжаргал дурсамждаа *«Анх бид хоёр 1972 оны намар галт тэргэнд танилцсан. ...Хэрэг зориг нь социологийн шинжлэх ухаан ихэд хөгжсөн Польш улсад нэг сарын хугацаатай ном үзэх томилоттой, “Надад туслаарай” хэмээн намуухан дөлгөөн дуугаар ярьж билээ.»* (ФСЭХ-ийн Социологийн хэлтэст нэгэн үед мөр зэрэгцэн ажиллаж байсан, Польш улсад социологич мэргэжлээр төгссөн Я.Мөнхжаргалын дурсамжаас, 2022) хэмээн тодорхой өгүүлсэн байдаг. Ингээд тодорхой бэлтгэл хангагдсаны дараа 1973 оны 7 дугаар сарын 20-

ны өдрийн 153-р тушаалаар Социологийн хэлтэсийн эрхлэгчээр томилж, 8 дугаар сарын 1-ээс ажил үүрэгт нь оруулсан байна.

Х.Нямбуу эрхлэгч болсныхоо дараа Р.Вандангомбо, С.Гомбо, Ц.Уртнасан, Ц.Дагвадаш, С.Дашдаваа, Х.Гүндсамбуу, Ц.Пүрэв нар болон Польшийн Лодзьын их сургуулийг социологич мэргэжлээр төгссөн Я.Мөнхжаргал нарыг ажилд авч шижигнэсэн залуучууд цуглаж, шинэ баг хамт олон бүрдэж эхэлжээ. Шинэ хамт олон бүрдэж эхлэхтэй хамт Монголд Социологийн шинжлэх ухаан үүсэн бүрэлдэх, хөгжих явц зэрэгцэж, Монгол дахь Социологийн шинжлэх ухааны нэгэн тулгуур, мэдлэгийн төв цэцэглэж эхэлсэн гэж хэлж болно.

ФСЭХ, Социологийн секторын эрхлэгч Х.Нямбуу тэргүүтэй залуу судлаачдаа 1975 оны 3-р сарын 10-наас 9-р сарын 10 хүртэл 6 сарын хугацаатайгаар СССР-ын ШУА-ийн Социологийн судалгааны институтэд “Судлаач-мэргэжил дээшлүүлэгч”-ээр сургаж монголд социологийн салбарыг үүсгэн байгуулагч болох хувь заяа тохиосон юм.

Түүний социологийн анхны бүтээл нь болох “Хөдөлмөрт хандах харьцааны нийгэм судлалын шинжилгээ хийсэн дүнгээс” нэртэй өгүүлэл “Түүхийн судлал” -ын 1973 оны дугаарт нийтлэгдсэн, дараа нь уг судалгаагаа өргөтгөн 1974 онд “Нийтийн хоолны үйлчилгээний хөдөлмөрийн социологийн зарим асуудал” хэмээх анхны социологийн судалгааны номыг ШУА-ийн хэвлэлийн газарт хэвлүүлжээ.

Доктор Ц.Уртнасан, *«Манай сектор анх байгуулагдаж судлах сэдвээ сонгох үед Нямбуу дарга маань нийгмийн бүтцийн судалгааг барьж авбал бидэнд ирээдүй байна гэж хэлж байж билээ. Үнэхээр ямар холыг харсан, монголын социологийн шинжлэх ухааны үндсэн чиглэлийг тодорхойлсон гэдгийг бид одоо л ухаарч байна»* хэмээн дурсамждаа өгүүлсэн байдаг. Үнэхээр ч Социологийн хүрээлэнгийнхэн, хүрээлэн байгуулагдсан цагаас эхлэн нийгмийн бүтцийн чиглэлээр тасралтгүй ажилласан, ажиллаж байгаа, Социологийн хүрээлэнгийн суурь судалгааны үндсэн чиглэл нь нийгмийн бүтцийн судалгаа гэж хэлж болно. Түүний эхлэл болгож, шанг татаж “БНМАУ-ын нийгмийн бүтэц” сэдэвт суурь судалгааны ажлыг 1976-1980 онуудад хийж гүйцэтгэжээ. Үүнээс *«...ажилчин, малчдын хөдөлмөр, ахуй, гэр бүлийн асуудлыг судлахдаа нийгмийн бүтэцийн асуудлыг Ц.Уртнасан, Х.Гүндсамбуу, хөдөлмөрт хандах харьцаа (Ц.Дагвадаш), соёл (С.Дашдаваа), аж байдал (Ц.Пүрэв, Ц.Төрбилэг), чөлөөт цаг (С.Гомбо), ухамсар, сүсэг бишрэл (Р.Вандангомбо) нар хариуцан авч задлан шинжилжээ»* (Философийн Хүрээлэнгийн хагас зууны түүхэн товчоо, 2022).

Дэлхийн социологичдын IX их хурал Швед улсад 1978 онд болж Х.Нямбуу нь С.Норовсамбуутай хамтран “БНМАУ социализмд дэвшсэн нийгмийн хөгжлийн асуудлууд, түүний орчин үеийн хандлага ангийн бүтцийн өөрчлөлтийн жишээн дээр” гэсэн илтгэлийг хэлэлцүүлж байжээ. Эргэж ирээд Х.Нямбуу хурлын мэдээг бичихдээ “социалист орон тус бүрийн социологийн шинжлэх ухааны хөгжлийн түвшнийг өндөржүүлэн, орчин үеийн хөрөнгөтний социологийг шүүмжлэх явдлыг улам хүчтэй өрнүүлэх нь чухалчлагдаж байна” гэжээ (Б.Содовсүрэн).

Тэрээр социологийг өөрийн унаган сонирхолтой уялдуулан угсаатны социологийн судалгааг үргэлжлүүлсээр байв. Социологийн секторынхоос анх түрүүн 1978 оны 3 сарын 4-ний өдөр Х.Нямбуу, профессор Д.Дашжамцын удирдлагын дор “Орчин үеийн монголын заншил, ёс горимын төлөвшил” гэсэн сэдвээр философийн ухааны дэд эрдэмтний зэргийг дотооддоо амжилттай хамгаалав. ФСЭХ-ийн Социологийн секторын эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд эрдэмтэн Р.Гүр “Өнөөгийн Монгол ёс” хэмээх бүтээлд шүүмж бичихдээ

“Социалист аж төрөх ёсны бүрэлдэхүүн хэсэг болсон социалист ёс заншил тус оронд төлөвшиж буй байдал, онцлог, түүнийг цаашид боловсронгуй болгож хөгжүүлэх асуудлыг этно-социологийн судалгаанд тулгуурлан авч үзжээ” гэсэн байдаг (Р.Гүр “Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн ҮГ таван жилд нийлүүлсэн ном, бүтээлийн тухай, 1982).

Нэрт эрдэмтэн Х.Нямбуу 1982-1985, 1988-1991 онд ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн дэргэдэх философи, хууль зүйн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байв.

### **5. Баруун хязгаарт.**

Х.Нямбуу нь ШУА-ийн илгээлтээр Ардын боловсролын яамны коллегийн 1983 оны 10 сарын 27-ны өдрийн шийдвэрээр 11-р сарын 1-нээс Ховд дахь Багшийн дээд сургуульд Нийгмийн ухааны тэнхимд нэг жилийн хугацаатай томилогдон очжээ. Түүний эхнэр Ц.Сэлэнгэ нь тус сургуулийн цэргийн сургалтын тэнхимд очиж их эмч багшаар ажилласан байна (БНМАУ-ын Ардын боловсролын яамны харьяа Ховд аймаг дахь Багшийн дээд сургуулийн ректорын тушаал, 1986). Тэрээр Ховдод 27 сар Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгчээр ажиллаж, ректорын хуралд сууж, багш Ц.Ганболд, П.Доржсүрэн, Х.Чинбаяр, Ц.Баасандорж нартай нэг тэнхимд ажиллаж байжээ. Х.Нямбуу нь “Марксист ленинист философи, Шинжлэх ухааны коммунизмын онол, БНМАУ-ын түүх, Монголын угсаатны зүй, Монгол хэлний түүхэн зүй, Хичээнгүй бичиг зэрэг хичээлийг заажээ” (МУИС-ийн Ховд дахь их сургууль, 2001). Ц.Баасандорж энэ үеийг “Х.Нямбуу багш маань бидэнд сургалтын талаар төдийлөн юм хэлэхгүй ч судалгааны ажил хийхийг сануулан шаардаж өөрөө үлгэрлэнэ” гээд, мөн “Х.Нямбуу багш маань хааяа биднийг хаягандаа цадчихаад юм хийхгүй байна хэмээн зэмлэнэ. Тэр нь дээд сургуулийн багш гэсэн нэрдээ ханачхаад эрдэм шинжилгээний ажил хийхгүй байна гэсэн зэм юм” гэжээ (Ц.Баасандорж, 2019).

Ховдод ажиллаж байх үедээ, ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн, Ховд дахь УБДС-ийн Нийгмийн ухааны салбар хамтран эдийн засгийн өрнөд мужийн хүн амын аж төрөх ёсны хөгжлийг судлах ажлыг хэрэгжүүлжээ. Тус ажлын хүрээнд өрнөд мужийн аймгуудад 1986 онд социологийн судалгаа хийж, ажиглалт, сурвалжилга, бичиг баримтын судалгаа явуулж, судалгааны үр дүнд 1989 онд “Монголын өрнөд нутгийн хүн амын аж төрөх ёсны хөгжил” хэмээх нэг сэдэвт зохиолыг ФСЭХ, Ховд дахь багшийн дээд сургуулийн Нийгмийн ухааны багш нар хамтран туурвижээ.

Доктор Х.Нямбуу тус нэгэн сэдэвт зохиолын зохиогч, редактороор ажилласан байна. Тэрбээр уг зохиолын 5 дугаар бүлгийн II зүйл “Олон угсаатны хөгжил, хандлага” хэмээх зүйлийг дагнан бичиж, түүндээ баруун халхчууд, ойрад монголчуудын тархалт, засаг захиргааны зохион байгуулалт, эдийн болон оюуны соёлын талаар өгүүлжээ. Ийнхүү тэрбээр 1983-1986 онд Ховд дахь УБДС-д ажиллаж байхдаа сургалтын ажлын зэрэгцээ өөрийн биеэр үлгэрлэн олон залуу багш нарыг судалгаа шинжилгээний ажилд татан оролцуулсан нь тус сургуулийн багш нар эрдэм судалгааны ажилд суралцах, чадваржихад чухал хувь нэмэр болсон юм (Б.Нямдорж, Ч.Лхагвасүрэн, С.Дорж, 2019).

Ховдод ажиллаж амьдарч байхдаа Ховдын театрын зураач, Монгол улсын урлагийн гавьяат зүтгэлтэн М.Амгалан, Монгол улсын гавьяат багш, зураач, угсаатны зүй судлаач А.Баасанхүү, МУЭ-ийн шагналт, нэрт зураач Д.Мишиг, Захчины нэрт бийч О.Дашдорж нартай ойр дотно нөхөрлөж байжээ.

Х.Нямбуугийн Ховд дахь багшийн дээд сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгчээр ажилласан он жилүүд цаашид угсаатан судлалаар дагнан ажиллах, гүнзгийрүүлсэн судалгаа хийх үндэс суурийг тавьсан бөгөөд Монголын олон угсаатны

бүлэг нутагшин суусан эл нутаг түүний хээрийн шинжилгээ хийх, ирээдүйн угсаатан судлаачийн судалгааны материалын баазыг бүрдүүлэх үндсэн талбар болсон юм. Эдгээр материал нь түүний 1980-1990-ээд онд монголын угсаатны зүй, монголын ёс заншил түүх, соёлын асуудлаар бичиж туурвисан хэд хэдэн суурь бүтээлийн үндэс болсон байна. 1986 оны 2-р сарын 17-ны Ховдын багшийн Дээд сургуулийн ректорын тушаалаар тэрээр 1986 оны 2-р сарын 25-наар ажлаас чөлөөлөгдөж (БНМАУ-ын Ардын боловсролын яамны харьяа Ховд аймаг дахь Багшийн дээд сургуулийн ректорын тушаал, 1986) МУИС руу шилжин иржээ.

## **6. Угсаатны зүйч**

Оюутан цагаасаа академич Б.Ренчиний шавь байсан, энэ тухай тэрээр “Ре багшаас угсаатны зүйн талаар номын рашаан хүртсэн хүний нэг молхи миний бие бөгөөд түүний үүсгэсэн “Угсаатан судлал-хэл шинжлэл”-ийн сургуулийг залган хөгжүүлэхийн төлөө чармайн зүтгэж явна” гэж дурдсан байдаг (Х.Нямбуу, 1990).

Нямбуу, монгол хэл уран зохиол – угсаатны зүй, түүх судлал – философи, социологи энэ гурван ухааныг өөрт нь “Их сургуулиас хайрласан эрдэнэт гурван хүлэг” гэж ярьдаг байжээ. Тэгэхдээ тэрбээр өөрийн хамаг эрдэм ухаан, авьяас чадвар, хүч хөдөлмөрөө зориулан дайчилсан эрдэм судлалын талбар бол монголын угсаатан судлал, ёс заншлын түүхэн болон орчин үеийн асуудал байв. Угсаатны зүйн асуудлаарх түүний гол бүтээл бол “Монгол хувцасны товчоо” (Уб., 1989), “Монголын угсаатны зүйн удиртгал” (Уб., 1992), “Монголын хувцасны түүхээс” (Хөх хот, 1994), “Монголын хувцасны түүх” (Түүх, угсаатны зүйн туурвил) (Уб., 2002) гэсэн зохиолууд юм. Түүнчлэн “Монголын өрнөд нутгийн хүн амын угсаа гарал, соёлын асуудал” (Хамтын бүтээл. Уб., 1988), “Монгол угсаатны бага тайлбар толь» (Хамтын бүтээл. Уб., 1993), “Монгол хувцасны нэвтэрхий толь. А боть. №1 (Хамтын бүтээл. Уб., 1993) зэрэг хамтын бүтээлийн бүлэг, зүйл, олон тооны толгой өгүүлэл, мөн эрдэм шинжилгээний бие даасан өгүүлэл, илтгэл олныг бичиж нийтлүүлжээ.

Х.Нямбуу нь 1991 онд МУИС-ийн “Монгол судлалын хүрээлэн” -гийн Ц.Шагдарсүрэнгэй хамтран анх удаа “Монгол судлалын бичиг” хэмээх сэтгүүлийг эрхлэн гаргаж байжээ. Х.Нямбуу 1992 онд нийтлүүлсэн “Монголын угсаатны зүйн удиртгал” хэмээх бүтээлдээ Монгол угсаатны гарал үүсэл, түүхэн нутагшил, дэлхий дахинаа тархсан монгол угсаатнуудын асуудлыг авч үзэж нэгтгэн дүгнэсэн бөгөөд эл бүтээл нь их, дээд сургуульд үзэх угсаатан судлалын хичээлийн гарын авлага болсоор байна. Энэхүү номын талаар манай нэрт эрдэмтэн профессор Д.Хүүхэнбаатар “Бяцхан оршлоос үүдэн санаж сэдэхүй” өгүүлэлдээ “1. Монголын угсаатны зүйн үечлэлийг шинэчлэн тогтоосон. 2. Монголын угсаатан судлалын цаашдын төлөв зорилтыг цаашдаа угсаа-нийгмийн болон угсаа-соёлын асуудлыг шинжих нь өнөөгийн угсаатан судлалын гол чиг баримтлал гэж тодорхойлсон. 3. ...монголчуудын эртний өвөг дээдсийн асуудлыг авч үзэхдээ “Бида” улсын тухай зоригтой хэлж, “хүннүчүүдийг палеосибирийн болон Төв Азийн хэв маягт хамаардаг Монголын өвөг дээдэс мөн”, “Хүннү улс нь нийгмийн хөгжлөөрөө анхан шатны боол эзэмшигч, феодалын өмнөх үеийн шинж бүхий улс” гэсэн цоо шинэ дүгнэлт өгсөн” хэмээн тодруулан тэмдэглэсэн байдаг.

Уг номын талаарх сонирхолтой шүүмжийг антропологич Г.Мөнх-Эрдэнэ “Дотоод Ази” сэтгүүлийн 2016 оны ХҮШ дугаарт нийтлүүлсэн. Шүүмжид, “академич

Ш.Лувсанванданы монгол хэлний ангиллыг ашигласан, мөн орчин үеийн монголчуудын гарл үүсэл, угсаатны бүлгийн ангиллыг гаргаж социалист монголын үндэстэн ястны тухай олон зүйлийг уг номоос мэдэж болно” гэж дүгнэсэн байна (G.Munh-erdene , 2016)

### **7. Багш ба сурган хүмүүжүүлэгч**

Х.Нямбуу нь Ховдоос эргэж ирээд ФСЭХ-дээ очсонгүй. 1986 оноос МУИС-ийн Хэл бичгийн факультетын монгол хэлний тэнхимд багшаар ажиллаж эхэлсэн. МУИС-ын захирлын 1989 оны 6-р сарын 30-ны 403 тоот тушаалаар Х.Нямбууг Хэл бичгийн факультетийн монгол хэл шинжлэлийн тэнхимийн багшийн үүрэгт ажлаас чөлөөлсөн агаад тушаалд, “хувийн өргөдөл, тэнхим, факультетийн зөвшөөрөл, лабораторийн саналыг үндэслэн Монгол судлалын эрдэм шинжилгээний лабораторид эрдэм шинжилгээний ажилтнаар 7-р сарын 1-ний өдрөөс шилжүүлэн ажиллуулсугай” гэжээ. Энэ нь МУИС-д суралцаж байгаа гадаадын оюутан, судлаач нарт Монголын уламжлалт соёл, ёс заншлыг танилцуулах, судалгаа хийх зорилгоор байгуулагдсан “Монгол судлалын лаборатори” юм.

Х.Нямбуу ФСЭХ-нд ажиллаж байхдаа наяд оноос МУИС-ийн НУФ-д “Угсаатны зүй” хичээлийг цагаар зааж, оюутны дипломын ажлыг удирдаж эхэлжээ. Тэрээр жендер, уламжлалт ёс заншил, социалист үндэстэн, ястны буюу угсаатны бүлгийн сэдвээр диплом удирдаж байв. Дараа нь тэрээр Ховд дахь Багшийн Дээд сургууль, МУИС болон гадаад дотоодын бусад сургуулийн бакалавр, магистр, докторын ажлын удирдагчаар ажиллаж олон төрлийн хичээл зааж байв.

1989-1990 оны ардчилсан хувьсгалын явцад үндэсний үзэл баримтлал, уугуул соёл эргэж сэргэх явцад Монгол улсын дээд боловсролын агуулга өөрчлөгдөж “Монгол судлалын лаборатори”-ийг Нийгмийн ухааны факультетад шилжүүлэн угсаатны зүй, соёл судлалын тасгийн зохион байгуулалтыг (Ж.Болдбаатар, З.Баасанжав, Ц.Ганцог, С.Даваа , 2002) өөрчилж “Нийгмийн судалгааны төв”-ийг 1991 онд байгуулжээ. Нийгмийн судалгааны төвийн эрхлэгчээр Лу.Бат-Очир, секторын эрхлэгчээр Х.Нямбуу ажиллаж байв. Уг төвийг 1993 оноос “Монголын угсаатны зүйн судалгааны төв” болгож нэрийг өөрчилсөн. Х.Нямбуу нь 1992 оноос “Угсаатны зүй” сургалтын хөтөлбөрийг боловсруулж сургалт явуулах бэлтгэлийг хангаад 1993 оноос НУФ-ийн “Угсаатны зүй- Эртний судлалын тэнхим”-ийг С.Бямбадорж, И.Саруул нарын хамт үүсгэн байгуулж эрхлэгчээр ажиллаж эхлэв (Ш.Содном. МУИС Нийгмийн ухааны факультет., 2000). МУИС-ийн захирлын 1994 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 32 тоот тушаалаар Нийгмийн судалгааны төвийг Угсаатны зүйн төв болгон өөрчилж эрхлэгчээр нь Х.Нямбууг томилон ажиллуулсан ( З.Баасанжав, Ш.Содном, 2007), мөн онд түүнд МУИС-ийн дэд профессор цол олгов. 1994-1996 онд НУФ-ийн “угсаатан судлал” хөтөлбөрийн анхны магистрын зэрэг хамгаалсан хүн нь Х.Нямбуугийн удирдсанаар Д.Долгорсүрэн болжээ (З.Баасанжав, Ш.Содном, 2007). 1993 оны хавар НУФ-д элссэн ( З.Баасанжав, Ш.Содном., 2007) түүхийн ангийн оюутнуудаас санал авч “угсаатны зүй” хөтөлбөрөөр суралцах бүлгийг (10 орчим оюутан сонгосон) үүсгэж улмаар 1997 оны хавар НУФ-ийг “түүхч-угсаатны зүйч” гэсэн мэргэжлээр анхны 6 оюутан төгсчээ ( З.Баасанжав, Ш.Содном., 2007).

### **8. Кино ба уран бүтээл**

Х.Нямбуу нэгэн ярилцлагадаа “Бага, дунд сургуульд жүжгийн дугуйланд суралцаж байсан маань хожим жүжиг киноны талын тодорхой ойлгоцтой болоход нөлөөлсөн” гэжээ (Х.Нямбуу, 1993). Тэрээр 2-р арван жилд монголын нэрт найруулагч Г.Жигжидсүрэнтэй нэг ангид суралцаж байсан агаад түүхийн цөөнгүй кинонд хамтран ажилласан юм. Үнэхээр ч Х.Нямбуу эрдэм судлалын төдийгүй уран бүтээлч сэтгэлгээтэй, гоо зүй, уран сайхны

нарийн мэдрэмжтэй хүн байсан нь ажил бүтээлийнх нь нэгээхэн хэсгийг зураг урлал, кино уран бүтээл эзэлдгээс харж болно. Тэрээр анх түүхэн уран сайхны кинонд зөвлөхөөр ажиллаж байгаад улмаар өсөн торниж баримтат киноны цөөнгүй бүтээл, уран сайхны нэг киноны зохиолыг бичжээ.

Тэрээр Ичээнд нь” (1972), “Хатанбаатар” (1981), “Намрын халуун өдрүүд” (1985), Мандухай цэцэн хатан” (1988), “Алтан шонхор” (1989), “Хүн чулууны нулимс (1990), “Бүлээн нурам” (1990), “Мөнх тэнгэрийн хүчин дор” (1992) зэрэг 20-оод киноны зөвлөхөөр ажиллаж байжээ. Тэр дотроо найруулагч Г.Жигжидсүрэнгэй гар нийлж ажилладаг нь бүтээл туурвилаас нь харахад илэрхий. Х.Нямбуугийн зөвлөсөн кинонуудаас “Мандухай цэцэн хатан” кино хоёр нийгмийн зааг дээр гарч, нийгмийн оюун санааны сэтгэлгээний өөрчлөлт, төрт ёсны уламжлал, үндэсний бахархал, үндэсний үзэл баримтлалыг сэргээхэд туйлын чухал байв. Х.Нямбуу уг кинонд зөвлөхөөр ажиллаж соёлын үнэт өвийг бүтээхэд голлон оролцсоныг хамтран ажиллагсад нь дурсан ярьдаг. Тухайлбал, төрийн ёслол, бэлгэдэл, зан үйл, дэг жаяг, үг хэллэгийг сэргээн дэглэх, уран сайхны аргаар дэлгэн үзүүлэх, киноны жүжигчин, цэрэг дайчид зэрэг оролцогчдод ухуулан таниулах ажлыг хийж байжээ. Түүнчлэн ур дүй, авьяас билиг, гүйлгээ ухаанаараа уран бүтээлийн ур хийц, дүрслэл шийдлийг уран яруу болгоход түүний хувь нэмэр ихээхэн байсныг онцлон тэмдэглэдэг. Мөн 1992 онд Чингис хааны тухай монголын анхны “Мөнх тэнгэрийн хүчин доор” кинонд угсаатны зүйн зөвлөхөөр ажиллажээ.

Мөн тэрээр “Цагаан сар” (1989), “Их ёсны өмсгөл” (1992), “Өргөө нийслэл” (1994) зэрэг баримтат киноны зохиол, “Эргүнэ хонгийн домог” (1992) уран сайхны киноны зохиолыг ганцаараа болон хамтран бичсэн.

Дээр дурдсанаас гадна доктор Х.Нямбуу 1988-1989 онд Монгол телевизээр “Ардын уламжлал” теле нэвтрүүлгийг зохиож (12 зүйл) олон дугаарыг хөтлөн явуулдаг байлаа(М.Чойжил, 1997). Тухайн үед “Ардын уламжлал” цуврал нэвтрүүлэг нийгэмд ус, агаар мэт хэрэгтэй байсан юм. Эргээд бодоход, энэ нь Монголчуудын хүндлэх мэндлэх, шинэлэх ёсноос эхлээд, ардын уламжлал, ёс заншлын талаар өгүүлсэн маш сайхан нэвтрүүлэг болж монголчуудын үндэсний ёс заншил, зан үйлээ сэргээхэд туйлын чухал үүрэг гүйцэтгэсэн.

## **9. Төрийн соёрхолт эрдэмтэн**

Х.Нямбуу дунд сургуульд сурч байсан үеэ дурсахдаа “Ардын зураач О.Цэвэгжав багшийн удирдсан уран зургийн дугуйланд дунд сургуульд байхдаа хичээллэж энэ талаар авьяас маань цоороогүй гэлээ ч угсаатны ахуйн хувцас хунар, эмээл хазаар юу тааралдсаныг өнгө зүсээр нь ялган буулгадаг чадвар үлдсэн гэжээ (Х.Нямбуу, 1993). Чухам энэ ур чадвар нь монгол хувцасны нарийвчилсан судалгааг хийх үндэс болсон байна. Х.Нямбуу 1993 онд олон жилийн судалгааны үр дүнгээ нэгтгэж “Монгол хувцасны түүх” сэдвээр түүхийн ухааны докторын зэрэг хамгаалжээ.

Эрдэмтэн эл бүтээлдээ монгол хувцасны түүхэн хөгжил, эд өлгийн соёлын төрх, залгамжлалын байдлыг эртний Хүннү, Сяньби, Түрэгийн үеэс эдүгээ үеийг хүртэл судлан, хаад ноёдын хувцсыг зэрэг дэвээр нь ялган гаргасны дээр Монголын цэргийн жанжны дүрэмт хувцас, лам санваартны өмсгөл хийгээд монголын олон ястан болон монголын зан үйлийн хувцас, цамын бүжгийн хувцас, бөөгийн өмсгөл, эрийн гурван наадмын хувцас хэрэглэл, дэлхийн олон оронд оршин суугаа монгол угсаатны хувцас, гоёлыг нарийвчлан судалжээ. Эл бүтээл нь урьд өмнө төдийлөн судлагдаагүй нарийн нийлмэл асуудлыг ул суурьтай шинжилж нэгтгэн дүгнэсэн эрдэм шинжилгээний болон практикийн чухал ач

холбогдолтой бүтээл болсон тул 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Төрийн соёрхол хүртээжээ.

Монгол хувцасны түүх” бүтээлийн судалбар олон зургийг өөрөө зурж үлдээсэн нь хувцасны түүх төдийгүй уран сайхны соёлын өв болон үлдсэн байдаг. Түүний зурсан зарим загвараар зохион бүтээгч Б.Дунгаамаа агсан хувцас урлан бүтээсэн нь уламжлалт соёлыг сэргээн бүтээх үнэ цэнтэй хувь нэмэр болжээ.

### **10. Соён гэгээрүүлэгч**

1990 онд ардчилсан хувьсгалын дараа монголын анхны ардчилсан үндсэн хуулийг батлах үйл явцад Х.Нямбуу нь уламжлал, ёс заншил, угсаатны зүйн мэргэжилтний хувьд оролцож өөрийн хувь нэмрийг оруулсныг анхны Ерөнхийлөгч П.Очирбат өөрийн “Тэнгэрийн цаг” номдоо тэмдэглэсэн байдаг (П.Очирбат, 1996).

Х.Нямбуу нь боловсролын үйл ажиллагааны зэрэгцээ үндэсний ухамсрын сэргэлт, уламжлалт соёлоо сэргээх нийгмийн үйл ажиллагаанд онцгой анхаарч байсан нь Монгол улсын ерөнхийлөгчийн дэргэдэх “Эрдэмтдийн зөвлөл”-ийн гишүүн, “Монгол өв уламжлал-ёс заншил хөдөлгөөн”, “Дэлхийн монгол туургатны холбоо”, “Монгол хувцасны нийгэмлэг”, “Монголын эв нэгдлийн холбоо”, “Монгол суу билэгтэн” сан, “Монголын тогоочдын холбоо”, “Монгол төрийн их өргөө/Автай сайн хааны өргөө” зэрэг олон байгууллагад тэргүүлэгчийн сонгуульт үүрэг гүйцэтгэж байснаас тодорхой харагддаг байна.

Энд онцлон тэмдэглэвэл зохих нэгэн чухал зүйл бол Нямбуу олон жил хийсэн нарийн судалгаандаа үндэслэж төрийн ёс, ёслол, түүнчлэн нийгэм, иргэний амьдрал, үйл ажиллагааны ёс, ёслолын олон журмыг боловсруулж хэвшүүлэн мөрдүүлэхэд хосгүй том үүрэг гүйцэтгэсэн явдал юм. Тэрбээр энэ талаар 1970-1990-ээд онд нийтдээ 20 гаруй практик зөвлөмж, горим, журам, санал боловсруулж холбогдох дээд байгууллагад өгч сайшаал талархал хүлээжээ.

1992 онд Чингис хааны мэндэлсний 830 жилийн ойд зориулан туурвисан “Хүндлэхийн дээд Хөх Монголын төрийн ёсон” хэмээх сонирхолтой ном нь хэвлэгдэн олны хүртээл болжээ. Энэ номыг түүхч И.Саруул “эрт дээр үеэс энэ зууны эхэн хүртэл монголчуудаас төрийн ёсыг боловсруулан тогтоож баримтлан ирснийг харуулжээ. Дээрх номд тусгасан ёсыг эмхэтгэн дүгнэх, хэвлүүлэхэд доктор Х.Нямбуу их хөдөлмөр гаргаж эрин үе ба ирээдүй үедээ бүтээлээ зориулжээ. Энэ номд төрийн бэлгэдэл, найр хурим, дөрвөн цагийн баярын тухай өгүүлсэн нь уул бүтээлийг нэн сонирхолтой бөгөөд сургамжтай болгожээ” гэжээ (И.Саруул, 1998 оны 5-р дугаарт (142)).

Эрдэмтний бие даан туурвин нийтлүүлсэн ном бүтээл 20 гаруй, хамтын бүтээлийн бүлэг зүйл, хамтран зохиосон тайлбар болон нэвтэрхий толь 10 гаруй, эрдэм шинжилгээний болон танин мэдэхүй, эрдэм шинжилгээний хялбарчилсан өгүүлэл, нийтлэл, илтгэл 50 гаруй, практик зөвлөмж, санал, горим, журам 20 гаруй, өөрөө зохиосон болоод зөвлөхөөр ажилласан уран сайхны болон баримтат кино 19, хянан тохиолдуулсан ном бүтээл 10 орчим, нийтдээ ойролцоогоор 120 орчим бүтээл тоологдоод байна.

### **11. Дүгнэлт**

Бурхан түүнд эгэлгүй их авьяас, билиг танхай ой ухаан, урлах эрдмийн ур дүй, олныг хөгжөөн баясгах, уран өгүүлэх чадвар, уужим бодь сэтгэлийг харамгүй заяажээ. Мөн хэн хүнд байхгүй мэдрэмж, хөдөлмөрч чанарыг хослуулжээ. Х.Нямбуу хүний амьдралын баяр жаргал, зовлон бэрхшээлтэй амаргүй замыг туулж хоёр нийгмийг дамжин өөрийн бүтээл

туурвилаа тасралтгүй хийж иржээ. Тэр бээр эрдэм мэдлэг, ухаан сэтгэлгээ, бичиж туурвих чадвар, эрч хүч, амьдралын туршлага ид тэгшрэн жагсаж онолдсон тавин зургаан насандаа, манай орны нийгэм, соёл, шинжлэх ухаан эрх чөлөөтэй болсон шинэ цаг үед 1998 оны 1 дүгээр сарын 3-нд зуурдаар тэнгэрийн оронд морилон одсон юм.

Түүхч угсаатны зүйч төрийн соёрхолт эрдэмтэн Х.Нямбуу багшийн энгийн, яруу монгол бичлэг, ур нарийн сэтгэлгээ, салбар дундын өргөн цараатай судалгааны бүтээл нь Монголын түүх-угсаатны зүйн сэтгэлгээнд өөрийн байр суурийг хэдийнээ эзэлжээ. Түүний бүтээл туурвил нь хоёр нийгмийн өөрчлөлтийн явцад монгол хүн үндэс язгуураа санаж, төрт ёс, өв соёлоо сэргээж, үндэсний нэгдмэл үнэт зүйлээ урлахад жинтэй хувь нэмэр болсон бөгөөд Монгол үндэстний түүх, монгол хүний ижилсэл-ондоошлын суурь судалгаанд болон бүхэлдээ монгол судлалд туйлын үнэ цэнтэй, давтагдашгүй содон өв болон үлдэж байна.

Х.Нямбуугийн хань Ц.Сэлэнгэ, охин Н.Өнөржаргал, Н.Золжаргал нарын хамт өдгөө АНУ-д амьдарч байна. Х.Нямбуугийн дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор эдүгээ төрсөн нутаг Дундговь аймгийн Адаацаг сумын дунд сургуулийг түүний нэрэмжит болгож, хөшөөг нь босгожээ.

#### Ном зүй

- З.Баасанжав, Ш.Содном. (2007). МУИС. Нийгмийн шинжлэх ухааны сургууль (тоон баримтын эмхэтгэл). УБ.
- G.Munh-erdene . (2016). “Nyambu Khand” Inner Asia.
- Б.Нямдорж, Ч.Лхагвасүрэн, С.Дорж. (2019). Ховд их сургууль. Дурсамж дүүрэн 40 жил” Адмон.
- Б.Содовсүрэн. *Философи, эрхийн судлал*. УБ: ШУА-ийн хэвлэх үйлдвэр.
- БНМАУ-ын Ардын боловсролын яамны харьяа Ховд аймаг дахь Багшийн дээд сургуулийн ректорын тушаал. (1986, 02 17).
- БНМАУ-ын ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын тогтоол. 1969.05.27, №. (2012). *ФЭС-ХХҮИ боть*. УБ: ЗХУ-д явуулах тухай. Үндэсний Төв Архив 148 дахь хуудас.
- Г. Чулуунбаатар. (2012). *Шинжлэх ухааны академид Философи, Социологи, Эрх зүйн Хүрээлэн үүсгэн байгуулахад доктор, профессор Д.Дашжамцын оруулсан хувь нэмэр, ФЭС-ХХҮИ боть*. УБ.
- Ж.Болдбаатар, З.Баасанжав, Ц.Ганцог, С.Даваа . (2002). “МУИС-ийн түүхийн товчоон” . УБ.
- И.Саруул. (1998 оны 5-р дугаарт (142)). Төрийн соёрхолт доктор Хандын Нямбуу”. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. УБ.
- МУИС-ийн Ховд дахь их сургууль,. (2001). *Хамт олон мөнхийн дурсамж*. УБ.
- П.Очирбат. (1996). Тэнгэрийн цаг. УБ.
- Р.Гүр “Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн ҮИ таван жилд нийлүүлсэн ном, бүтээлийн тухай. (1982). *философи эрхийн судлал*. УБ.
- С.Бадамхатан, Х.Нямбуу. (1964). Дархад ардын дээл. *ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Халх Дархадын этнографийн бүтээл*, 41-45-р тал.
- Философийн Хүрээлэнгийн хагас зууны түүхэн товчоо. (2022). Салбаруудын түүхэн замнал: Социологийн салбар. УБ.

- Х.Нямбуу. (1963). Дархад эмээлийн зүйлээс товчхон.-/Эрдэм шинжилгээний өгүүлэл. *МУИС-ийн оюутны эрдэм шинжилгээний бүтээл*, №3.
- Х.Нямбуу. (1990). *Угсаатны зүйч/нийтлэл*. “Үнэн” сонин, , №287.
- Х.Нямбуу. (1993). Өөдлөхөд өнгө нэмэв. *Нийслэлийн сонин бичиг сонин*, №7.
- Ц.Баасандорж. (2019). *Захирлуудын дурсамж*. УБ: Ховд их сургууль.
- Ц.Өлзийхутаг, Н.Цэдэвсүрэн. (1974). Сурган хүмүүжүүлэгч. In Н. Ц.Өлзийхутаг. УБ: Ардын боловсролын яам.
- Ц.Пүрэв, А.Жамбал. (2012). “Монголын анхны социологичдын нэг, угсаатан, ёс заншил судлалын нэрт эрдэмтэн Хандын Нямбуу. *ФЭС-ХХҮИ боть*. УБ.